



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ



АРХИВЫН ЕРӨНХИЙ
ГАЗАР

“ХУУЛЬ ЗҮЙН АЛБАНЫ ТҮҮХЭН ЗАМНАЛ”

АРХИВЫН БАРИМТ БИЧИГ,
ГЭРЭЛ ЗУРГИЙН ҮЗЭСГЭЛЭН

2016 он



ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ



АРХИВЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

Эрхэм хүндэт Таныг

“ХУУЛЬ ЗҮЙН АЛБАНЫ ТҮҮХЭН ЗАМНАЛ”

сэдэвт архивын баримт бичиг, гэрэл зургийн үзэсгэлэнд
морилон ирэхийг урьж байна.



Үзэсгэлэнгийн нээлт
2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 11 цагт
Монголын үндэсний музейн үзэсгэлэнгийн танхимд болно

ӨМНӨХ ҮГ

Цагаагчин гахай жилийн Үндэсний эрх чөлөөний хувьсгалын үр дүнд 1911 оны 12 дугаар сарын 29-нд Монгол Улсын хаан ширээнд VIII Богд Жибзундамба хутагтыг өргөмжилж, Дотоод Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яам, Гадаадын Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яам, Цэргийн Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яам, Сангийн Хамаг Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яам, Шүүх Таслах Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яам гэсэн төрийн таван яамнаас бүрдсэн Монгол Улсын байнгын Засгийн газрыг байгуулсан юм. Тийнхүү нэгэн зуун таван жилийн тэртээ төрийн таван яамны нэгээр байгуулагдсан Шүүх Таслах Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яам нь Монгол Улсын орчин цагийн хууль зүйн албаны эх үүсгэл болжээ.

Түүхийн энэ тэмдэглэлт ойг тохиолдуулан Монгол Улсын Архивын ерөнхий газраас эрхлэн “Хууль зүйн албаны түүхэн замнал” сэдэвт архивын баримт бичиг, гэрэл зургийн үзэсгэлэнг олон нийтийн хүртээл болгож байна.

Энэхүү үзэсгэлэнгийн үзмэрүүд нь Архивын ерөнхий газрын Үндэсний төв архивын сан хөмрөг дэх баримт бичиг, гэрэл зураг болон Цагдаагийн ерөнхий газрын музей, Хил хамгаалах ерөнхий газрын музейн биет үзмэр зэрэг 200 орчим үзмэрээс бүрдэж байна.

Үзэсгэлэнд тавигдсан үзмэрүүд нь XX зууны эхнээс энэ зууны эхэн хүртэлх зуу гаруй жилийн хугацаан дахь Монгол Улсын хууль зүйн албаны түүхэн замнал, ялангуяа Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний агентлаг, харьяа байгууллагуудын түүхэн хөгжлийн эхэн үеийг тодотгон харуулахад чиглэгдсэн болно.

Үзэсгэлэнд 1911 оны 12 дугаар сарын 29-нд Шүүх Таслах Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яамны тэргүүн сайдаар улсад туслагч гүнгийн зэрэг, засаг тэргүүн зэрэг тайж М.Намсрайг томилсон Богд хаантаны зарлиг, М.Намсрай Богд хаантаны шагнасан тамгыг хүлээн аваад яам байгуулж, хэрэг шийтгэснийг айлтгасан айлтгал, 1913 онд Богд хаантаны зарлигаар батлагдсан Шүүх Таслах Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яамны эрхлэн шийтгэх хэргүүд, мөн тус яамны албан хаагчдын тангарагийн эх, яамны бүтэц, орон тоо, эрхлэн шийтгэх хэргийг Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичгийн заалт, 1921 оны 2 дугаар сарын 22-нд сэргээн босгосон Автономит Гадаад Монгол Улсын төрийн яамдын тэргүүн, дэд сайдыг томилсон Богд хаантаны зарлиг, 1921 оны 7 дугаар сарын 11-нд Ардын эрхтэй Засгийн газрыг байгуулж, төрийн яамдын сайд, түшмэдийг томилсныг Богд хаантанд айлтгасан айлтгал зэрэг тус яамны үүсэл хөгжилд холбогдох нэн чухал баримт бичгүүд, үе үеийн Шүүх Таслах Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яамны анхны тэргүүн сайдуудын гэрэл зураг, мөн Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг, байгууллагуудын түүхэн хөгжлийн эхэн үед холбогдох олон сонирхолтой баримт бичиг, гэрэл зураг тавигдсан юм.

Түүнчлэн тус үзэсгэлэнд хилийн цэргийн амьд түүх болсон дэслэгч генерал Б.Цэдэн-Иш, хоёр төрийн домогт сэргийлэгч Ж.Данзан нарын хувцас хэрэглэл, Хилийн цэрэг, Цагдан сэргийлэхийн ажилтан нарын хэрэглэж байсан буу зэвсэг, модон дохиур, бороохой, гал сөнөөгчдийн дохионы хонх, яамны байгууллагуудын захирлага, тэмдэг зэрэг биет үзмэрүүд тавигдсан болно.

Та бүхэн таалан болгооно уу.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ



Шашин төрийг хослон барьсан
наран гэрэлт түмэн наст Богд хаан



Шүүх Таслах Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч
Яамны анхны тэргүүн сайдаар М.Намсрайг
томилсон Богд хаантаны зарлиг. 1911.12.29




Шүүх Таслах Хэргийг Бүгд Захиран
Шийтгэгч Яамны шүтээн Дамжин Чойжил



Шүүх Таслах Хэргийг Бүгд Захиран
Шийтгэгч Яамны анхны тэргүүн сайд
М.Намсрай



Шүүх Таслах Хэргийг Бүгд Захиран
Шийтгэгч Яамны тамганы дардас



М.Намсрай Богд хаантаны шагнасан тамгыг хүлээн аваад яам байгуулж, хэрэг шийтгэснийг айлтгасан айлтгал. 1911.12.29



Богд хаантаны зарлигаар батлагдсан Шүүх Таслах Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яамны эрхлэн шийтгэх хэргүүд. 1913 он



Сэргээн босгогдсон Автономит Гадаад Монгол Улсын төрийн яамдын сайд, түшмэдийг томилсон Богд хаантаны зарлиг. 1921.02.22



Ардын эрхтэй Засгийн газрыг байгуулж, төрийн яамдын сайд, түшмэдийг томилсныг Богд хаантанд айлтгасан айлтгал. 1921.07.11



Сэргээн байгуулагдсан Автономит Гадаад Монголын Шүүх Таслах Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яамны тэргүүн сайд, бэйс Чимэддорж



Нийгмийн хэв журам сахиулах комендантын дарга Л. Дэмбэрэл. 1921 он



Дотоодыг хамгаалах газрын анхны дарга Д. Балдандорж



Дээд шүүх таслах газрын анхны дарга Ц. Гүрсэд



Шүүх яамны албан хаагчдын орон тоо. 1922 он



БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийн эх. 1924 он



Улсын прокурорын анхны дарга Чулуунбат



Цаг зуурын шүүх таслах газрын анхны дарга Х.Чойбалсан



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шүүх явдлын яамны дагаж явах дүрэм /Анхны дүрэм/. 1925 он



Шүүх явдлын яам болон аймгуудын шүүх таслах газруудын тамганы дардас.
1940 он



БНМАУ-ын хоёрдугаар Үндсэн хуулийн эх. 1940 он



БНМАУ-ын Үндсэн хуулийг баталж байгаа нь. 1940.06.30



Дотоод явдлын яамны ажилтан нарын орон сууц. 1943 он



Хууль зүйн албаны анхдугаар зөвлөгөөнд оролцогчид. 1979 он



Хүндэт чекистүүд. 1981 он



Онц сэргийлэгчид. 1981 он



Онц гал сөнөөгчид. 1981 он




Шүүх яамны сайд Б.Чимэд, I орлогч сайд О.Жамбалдорж, Шүүх яамны намын үүрийн дарга Д.Хүрлээ, Шүүх яамны орлогч сайд Х.Дамдин нар хүүхдийн эрх хамгаалах өдрөөр яамны албан хаагчдын хүүхдүүдийн хамт. 1981 он



Хууль зүйн яамны сайд Ж. Амарсанаа, I орлогч сайд Ц.Нямдорж, орлогч сайд Д.Ганболд нар ахмад ажилчдын хамт. 1991 он



Монгол Улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат шинэ Үндсэн хуульд тамга дарж баталгаажуулж буй нь, 1992 он



БНМАУ-ын дөрөвдүгээр Үндсэн хуулийн эх, 1992 он

ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГУУД Цагдаагийн ерөнхий газар



Дотоод явдлын яамны харьяанд Цагдан сэргийлэх газрыг байгуулахаар тогтоосон улсын Анхдугаар их хурлын 5 дугаар тогтоол. 1924.11.13



Сэргийлэх цэрэг байгуулах тухай Засгийн газрын зургадугаар хурлын тогтоол. 1921.07.19



Цагдан сэргийлэхийн морьт эргүүл. 1943 он



Улаанбаатар хотын гал сөнөөгчид бэлэн байдалд



Замын хөдөлгөөний дүрэм зөрчигчийг шалгаж байгаа нь. 1943 он



Улсын Цагдан сэргийлэх ерөнхий газрыг “Байлдааны гавьяаны улаан тугийн одон”-гоор шагнасныг гардуулж буй нь. 1966 он



Хоёр төрийн домогт сэргийлэгч
Ж.Данзангийн дүрэмт хувцас



Гал сөнөөгчдийн дохионы хонх



Монгол Улсын анхны цагдаа нарын хэрэглэж байсан усан баамлийн
хэмээх буу




Цагдан сэргийлэхийн ажилтан нарын хэрэглэж
байсан модон дохиур, бороохой

Хил хамгаалах ерөнхий газар



Бүх Монголын нутгийн зах хилийг чухам хэдийд аль газраар байгуулж, аль захтай хиллэж байсныг мэдүүлж ирүүлэхийг тушаасан Богд хаантаны зарлиг. 1913.10.13



Гурван улсын гэрээнд Монгол Улсын хил хязгаарын заагийг тогтоох талаар Монголын талаас оруулсан санал. 1915 он



Хилчид анхны застав байгуулах газраа ирж байгаа нь. 1933 он



Хилийн манаа байлдааны тушаал авч буй нь. 1938 он



Орос, Монголын хилчид, 1944 он



Дайны жилүүдэд хилийн отрядуудыг удирдаж байсан офицерууд, 1944 он




Хилийн цэргийн гуравдугаар тусгай морин сумангийн тэмдэг. 1926 он



Самгалдайн харуулын тэмдэгт мод

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГУУД

Архивын ерөнхий газар




Дотоод явдлын яамнаас хуучин данс харааг эмхлэн хураахад түшмэл, бичээч гарган туслалцуулахыг хүсч Судар бичгийн хүрээлэнд явуулсан бичиг. 1923.09.15



Судар бичгийн хүрээлэнд хуучин данс харааны эрхлэгчийн нэгэн орон тоог баталж, Ц.Лувсанг томилсон тус хүрээлэнгийн 10 дугаар хурлын тогтоол. 1927.12.05




Мэгжид Жанрайсэг сүмийг Улсын архивын газарт шилжүүлсэн гэрээ. 1942.04.18



Маршал Х.Чойбалсан тэргүүтэй нам, засгийн удирдагчид Улсын архивын ажил байдалтай танилцсан уулзалтын тэмдэглэл. 1951.06.02



Архивын задгай баримтыг цэгцэлж буй нь. 1930-аад он



Мэгжид Жанрайсэг сүмд хадгалагдаж байсан архивын цэгцлэгдээгүй баримт бичгүүд. 1940-өөд он



Архивчид манж хэл дээрх баримт бичгийг цэгцэлж буй нь.
1950-иад он



Аймаг, хотуудын улсын архивын ажилтан нарын анхдугаар
зөвлөгөөнд оролцогсод. 1959 он


Гадаадын иргэн, харьяатын газар



Гадаад яамнаас дагаар орохыг хүссэн Өвөр Монголын Лувсансодовын хүсэн батлах бичгийг Дотоод явдлын яаманд хүргүүлснийг мэдэгдсэн бичиг. 1930.02.04



Хяналтын улсын байцаагч гадаадын иргэнд зөвлөгөө өгч байгаа нь




Хяналтын улсын байцаагч нар

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар



Монгол Улсын иргэдийг паспортжуулах дүрмийг баталсан Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 67 дугаар хурлын тогтоол. 1940.12.13



Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулсан конвенцид нэгдэн орох тухай БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн 1978 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 248 тоот зарлиг




Улаанбаатар хотын захиргааны паспортын хэлтсийн тэмдэг



Монгол, Орос, Хятадын оюуны өмчийн байгууллагуудын 4 дэх удаагийн бага хурал. 2016.09.06

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар



Шүүх таслах яаманд гянданг дааж захирах түшмэл, хуяг бий болгосон тухай бичиг.
1912.01.25



Ударник хоригдлуудын байр




Ялтнуудын эргэлт, уулзалтын цаг



Шүүх таслах яамны Гянданы хэлтсийн тэмдэг

Хууль зүйн үндэсний хүрээлэн



Хууль зүйн үндэсний хүрээлэн байгуулах тухай Монгол улсын Засгийн газрын 18 дугаар тогтоол. 2009.12.21



Монгол улсын гавьяат хуульч Б.Чимэд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн ажилтан нарын хамт

Хууль сахиулахын их сургууль



Дотоодыг хамгаалах газрын дэргэдэх түр сургуулийг Хязгаарын ба гүйцэтгэх ажилчдыг бэлтгэх сургууль болгох тухай тус газрын даргын 994 дүгээр тушаал. 1924.12.06



Дотоод яамны төв сургууль.
1930-1950 он



Дотоод хэргийн их сургуулийн сонсогчид байлдааны тугийн дор

Хууль зүйн туслалцааны төв



Хууль зүйн туслалцааны төвийн дүрмийг баталсан Монгол Улсын Хууль зүйн сайдын А/22 тоот тушаал. 2014.03.11




Хууль зүйн туслалцааны төвөөс зохион байгуулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалт



ХЗТТ-ийн Булган аймаг дахь салбарын ажилтнууд иргэдэд эрх зүйн зөвлөгөө өгч буй нь. 2016.11.3.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг



Дотоодыг хамгаалах газрын эмнэлгийн анхны даргыг тохоон томилсон тус газрын даргын 234 дүгээр тушаал. 1923.06.07



Төв эмнэлгийн байр. 1938 он




НАХЯ-ны сайд Б.Дэжид, УЦСЕГ-ын дарга генерал С.Будрагчаа нар НАХЯ-ны эмнэлгийн ажиллагаатай танилцав. 1972 он

Монголын Нотариатын танхим



Улсын нотариатын контор байгуулах тухай БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 91 дүгээр тогтоол. 1953.03.14



Улсын нотариатын байгууллагыг Дээд шүүхийн харьяанд оруулах тухай БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 554 дүгээр тогтоол. 1964.12.13



Шүүх явдлын яам болон аймгуудын шүүх таслах
газруудын тамганы дардас.
1940 он